

БҮРТГЭЛ-ХЯНАЛТЫН КАРТ

ИХИ

Огчоо

2014 10. 01

Байгууллагын нэр
МНТ

Зохион байгуулалтын нэгж, ажилтны нэр

Бүртгэсэн	Хаанаас ирүүлсэн	Баримт бичгийн		
Сар, өдөр /ad/	Карт № 1607	13X - Голгох	Дугаар /ad/	Сар ... Хуудасны тоо *

Товч утга

Хяналтад тогтолцоогүйшигийн түүхтэй
бүртгэлийн түүхтэй тогтолцоогүйшигийн түүхтэй

III, AA, XA, IT, ZZX, (Холбоогүй)

Зорилж олонд хичигдэг чадв.

Удирдлагын заалт

Сар, өдөр ... 2014. 10. 23. Агуулжээ.



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 376

Улаанбаатар хот

“Улаанбаатар зочид буудал” ХК-ийн
үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 22 дахь зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар зочид буудал” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 335,297 /гурван зуун гучин таван мянга хоёр зуун ерэн долоо/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Компанийн тухай хуулийн 24.1, 53.1 дэх заалтын дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанийд эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдэд уг эрх үүссэн тухай болон түүнийг хэрэгжүүлэх журмын талаарх мэдээллийг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэхийг “Улаанбаатар зочид буудал” ХК /Н.Шүр/-д үүрэг болгосугай.

3. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүний дансанд байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг Компанийн тухай хуулийн 24.4-т заасан журмын дагуу өөрчлөн байгуулагдаж байгаа хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэж авах үүргийг хэрэгжүүлэхийг “Улаанбаатар зочид буудал” ХК /Н.Шүр/-д даалгасугай.

4. Тус компани хэлбэрээ өөрчилж, үнэт цаасны бүртгэлээс хасагдаж байгаатай холбогдуулан “Улаанбаатар зочид буудал” ХК /Н.Шүр/ болон “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

1/ Хувьцаагаа компанийд эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг нэгж хувьцаанд 106,245.58 /нэг зуун зургаан мянга хоёр зуун дөчин таван төгрөг тавин найман мөнгө/ төгрөгөөр тооцон “ҮЦТТХТ” ХХК-тай гэрээ байгуулж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь хувьцаа эзэмшигчдийн холбогдох дансанд энэхүү журам батлагдсан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор шилжүүлж хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх нөхцлийг хангах;

2/ Хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааг компанийд эргүүлэн худалдан авах шаардлагыг гаргасан тохиолдолд зохих журмын дагуу нэгж хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд шуурхай олгох;

3/ Ногдол хувийн мөнгөн хөрөнгийг төвлөрсөн хадгаламж дахь дансанд байршуулахдаа хувьцаагаа компанийд эргүүлэн худалдан авахыг шаардах эрх тухайн дансны эзэмшигчид үүссэн тухай тэмдэглэл хийж, харилцагч дансны хуулга авах тухай бүрд зохих тайлбарыг өгч ажиллах;

4/ Энэхүү тогтоолын 3-т заасан хүсэлтийг гаргасан тохиолдолд компанийн эзэмшил дэх хувьцаанаас хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчид эзэмшүүлж, түүний хариуд уг хувьцаа эзэмшигчийн төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд нь байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг тус компанийд шилжүүлж ажиллах.

5. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн өрөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

